



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
УЛААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 1/92

Төгөл

Балансын урамшуулал олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 оны жилийн эцсийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар "Өөрчлөлтгүй" дүгнэлт авсан Тамгын газрын дарга М.Батцогт, Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч Б.Хишигсүрэнд албан тушаалын үндсэн цалинг 2 сараар тооцон урамшуулал олгосугай.

2.М.Батцогт, Б.Хишигсүрэн нарын цалингийн урамшууллыг байгууллагын батлагдсан цалингийн сандаа багтаан олгохыг Тамгын газрын нягтлан бодогч Т.Намжилсүрэн-д зөвшөөрсүгэй.

3.Засаг даргын Тамгын газрын "Өөрчлөлтгүй" дүгнэлт авсан санхүүгийн ажилтнуудыг урамшуулахыг Тамгын газрын дарга М.Батцогт-д үүрэг болгосугай.

ДАРГА  М.БАТЦОГТ

